



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-ҮҮР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/46

Цагаан-Үүр сум

Г

Г

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны Ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны “Орон нутгийн боловсон хүчнийг бэлтгэх, дэмжих хөтөлбөрийг батлах тухай” 04 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Орон нутгийн боловсон хүчнийг бэлтгэх, дэмжих хөтөлбөр”-т хамрагдахыг хүссэн иргэдийг сонгон шалгаруулах, хөтөлбөрт хамруулах, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Ерөнхий боловсролын сургуулийн захирал

Эрүүл мэндийн төвийн дарга

Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч

Соёлын төвийн дарга

Ойн ангийн дарга

Ус цаг уурын өртөөний дарга

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга

Нарийн бичгийн дарга: Хууль, эрх зүйн мэргэжилтэн

2. Хөтөлбөрт хамрагдахыг хүссэн иргэдийн материалыг хүлээн авч, хурлаар хэлэлцүүлэн холбогдох журмын дагуу сонгон шалгаруулахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн мэдээлэл, хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг хагас, бүтэн жилээр Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурал, Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргад үүрэг болгосугай.

ДАРГА



А.БАТМӨНХ

6704301153